

Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ #1

Энэхүү Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээг (цаашид “Гэрээ” гэх) 2017 оны 5-р сарын 9-ний өдөр дараах талуудын (хамтад нь Талууд, тусад нь Тал гэх) хооронд байгуулсан болно:

1. Ханбогд сумын Засаг Захиргаа (цаашид **Ханбогд сум**);
2. Ханбогд сумын багуудын малчдын төлөөлөгчид (цаашид хамтад нь **Малчдын төлөөлөгчид гэх**);
3. Оюу Толгой ХХК (цаашид **ОТ**).

I. Гэрээний зорилго

- 1.1 Тус гэрээний зорилго нь Эрх Зүйн Хяналт, Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗХНЗОГ)-т 2012 оны 10 дугаар сард гаргасан малчдын гомдлыг барагдуулах Хавсралт 1-т заасан үйл ажиллагааг Талууд хамтран хэрэгжүүлэхэд оршино.

II. Гомдлын танилцуулга

- 2.1 Олон Улсын Санхүүгийн Корпорацийн (ОУСК) санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Өмнөговь аймгийн Ханбогд суманд хэрэгжиж буй Оюу Толгой төслийн нөлөөнд өртсөн өөрсдийгөө нутгийн уугуул иргэд гэж үзэж буй орон нутгийн нүүдэлчин малчид “Оюу Толгой Хяналт” үндэсний ТББ, Ханбогд сумын “Говийн Газар Шороо” орон нутгийн ТББ дэмжлэгтэйгээр Дэлхийн Банкны Группын ОУСК болон Олон Талын Хөрөнгө Оруулалтын Баталгааны Агентлагтай (ОТХОБА) холбоотой асуудлаар хөндлөнгийн хараат бус хариуцлагын механизмын үйлчилгээ үзүүлдэг Эрх Зүйн Хяналт, Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗХНЗОГ)-т 2012 оны 10-р сард гомдол гаргасан.
- 2.2 Гомдол гаргагчид нь ОТ-н төслийн улмаас нутаг орны бэлчээрийн газар, усны нөөцийг ашигласнаас үүдэн малчдын нүүдлийн амьжиргааг доройтуулж, улмаар тэдний уламжлалт соёл, амьжиргаанд эрсдэл учруулж байгаад санаа зовниж буйг гомдолд дурдсан бөгөөд нөхөн олговор болон нүүлгэн шилжүүлэлт зохих ёсоор хийгдээгүй, ялангуяа усны нөөц ховор бүс нутагт тогтвортой ус ашиглалтын асуудлыг тойрсон төслийн ажиллагаа зүй зохистой эсэхэд эргэлзэж буйгаа илэрхийлсэн.
- 2.3 Эрх Зүйн Хяналт, Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗХНЗОГ) нь уг гомдлыг үнэлгээний шалгуурыг хангасан гэж үзсэн бөгөөд 2012 оны эцсээр хийгдсэн үнэлгээний үйл явцын хүрээнд Гомдол гаргагчид болон Оюу Толгой компани нь ЭЗХНЗОГ-ын чиглүүлэл, туслалцаатайгаар сайн дурын үндсэн дээр гомдолд тусгагдсан асуудлыг хэлэлцээрийн замаар шийдэхээр хамтран ажиллахыг зөвшөөрсөн.

III. Маргааныг шийдвэрлэх үйл явц

- 3.1 Талууд 2013 оны 3-р сарын 15-наас 2017 оны 5-р сарын 9-ний хооронд ЭЗХНЗОГ-ын эвлэрүүлэн зуучлалын туслалцаатайгаар гомдлын маргааныг шийдвэрлэх үйл явцад оролцов.
- 3.2 Ханбогд сум, Малчдын төлөөлөгчид (МТ) болон ОТ-н хооронд Гурван Талт Зөвлөл (ГТЗ) байгуулах зорилгоор Талууд Харилцан Ойлголцлын Санамж Бичгийг 2015 оны 6-р сарын 8-нд байгуулж гарын үсэг зурсан юм. ГТЗ нь ЭЗХНЗОГ-т гаргасан гомдлуудтай холбоотой малчид, бэлчээр, ус болон холбогдох бусад асуудал, гомдол, санал санаачилга эсвэл зөвлөмжүүдийг авч үзэх, анхаарал хандуулах, шийдвэрлэх, тэдгээрийн талаар мэдээлэл солилцох,

¹2012 оны 10-р сард малчдын гаргасан гомдолд дурдсан үг хэллэгийг ашиглав.

- тэдгээрт холбогдуулан санал, зөвлөмжүүд гаргах, түүнийг хэрэгжүүлэх, зохих эрх бүхий байгууллагуудад уламжлах чиг үүрэгтэй болно.²
- 3.3 Маргааныг шийдвэрлэх үйл явцын хүрээнд Талууд баримтыг хамтран олж тогтоох үйл явцыг эхлүүлж, Ханбогд сумын малчдын амьжиргаанд ОТ-н төслийн нөлөөллийг үнэлэх Олон Талт Мэргэжлийн Шинжээчдийн Баг (ОТМШБ) хамтран сонгож, ажиллуулсан болно.³ Гурван бүрэлдэхүүн бүхий тус үнэлгээ нь ОТ үйл ажиллагаанаас малчдын амьжиргаанд учирч буй нөлөөлөл болон тэр нөлөөллийг нөхөх хөтөлбөр нь хангалттай эсэх талаар хараат бус мэдээлэл боловсруулахад чиглэсэн билээ. ОТМШБ нь ялангуяа бэлчээр ба худгийн усны хүртээмж болон чанарт бий болсон өөрчлөлтийг үнэлж малчдын амьжиргаанд хамаарах байдлыг судлав (Бүрэлдэхүүн хэсэг 1); ОТМШБ нь малчдын амьжиргаанд нөлөөлөх ОТ-н ерөнхий нөлөөллийг үнэлэв (Бүрэлдэхүүн хэсэг 2); дээрх үнэлгээний мэдээлэлд үндэслэн ОТ-н 2004 оны нүүлгэн шилжүүлэлт, 2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговорын хөтөлбөр нь дээрх нөлөөллүүдийг нөхөж чадаж байгаа эсэхийг үнэлжээ (Бүрэлдэхүүн хэсэг 3). ОТМШБ нь 2017 оны 1-р сард үнэлгээний ажлынхаа эцсийн тайлан болон зөвлөмжүүдийг⁴ Талуудад илгээсэн бөгөөд Талууд зөвлөмжүүдийг энэхүү Гэрээнд зааснаар хүлээн зөвшөөрч, хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллахаар тохирсон болно.

IV. Гомдлыг шийдэхээр тохиролцсон байдал

- 4.1 Талууд нь гомдлын асуудлуудаар зөвшилцөлд амжилттай хүрч, Хавсралт 1-д дурдсан Үйл Ажиллагааны Дэлгэрэнгүй Төлөвлөгөөг хэрэгжүүлж ЭЗХНЗОГ-т гаргасан гомдлын асуудлуудыг шийдэхээр тохиролцов.
- 4.2 Энэхүү Гэрээний Хавсралт 1-т ОТ дангаараа буюу хамтран хариуцаж хийхээр тохирсон бүх ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардал, санхүүжилтыг ОТ компани хариуцна.
- 4.3 Талууд энэхүү Гэрээнд заасан асуудлаар бүхэлд нь харилцан тохиролцсон бөгөөд Гэрээнд тусгасан заалтууд нь эцсийнх болно. Энэхүү Гэрээний хэрэгжилтийг Талууд бүрэн гүйцэд, үр дүнтэй, хангалттай хэрэгжүүлсэн гэж дүгнэсний дараа аль нэг тал нь Гэрээнд заасан асуудлаар маргаан, гомдол гаргахгүй болохыг Талууд харилцан тохиролцсон болно.
- 4.4 Энэхүү Гэрээний Хавсралт 1-т тохирсон үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжилтийн үр дүнд үүсч болзошгүй шинэ гомдол, маргаан нь тус Гэрээнээс салангид тусдаа гэж үзэх бөгөөд энэхүү Гэрээнд нэмж оруулахгүй болохыг Талууд харилцан тохиролцсон болно.

V. Энэхүү Гэрээг хэрэгжүүлэх тухай

- 5.1 Талууд Гэрээний Хавсралт 1-т тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд харилцан бие биедээ хүндэтгэлтэй, дэмжиж ажиллах бөгөөд аль нэг Талын хэрэгжүүлж буй ажлыг аюулгүй (бусдад хор хөнөөл учруулахгүй), үр өгөөжтэй байхыг чухалчилна.
- 5.2 Талууд энэхүү Гэрээнд тусгасан бүх нөхцлийг хэрэгжүүлнэ. Талууд шаардлагатай тохиолдолд харилцан зөвшилцөж, тохиролцон нэмэлт

²Гурван Талт Зөвлөл байгуулсан Харилцан Ойлголцлын Санамж Бичгийг үзнэ үү. http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/FinalSignedMoUwithAnnexures_MON.pdf

³ОТМШБ-ын Ажлын Даалгаврыг үзнэ үү. http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/MDTEOI_ENGandMON.pdf

⁴ОТМШБ-ын эцсийн тайлан болон зөвлөмжүүдийг үзнэ үү. http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/MDTIEP_FINALREPORT_MON_January292017_000.pdf

өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ. Ийм нэмэлт өөрчлөлт нь тус Гэрээний салшгүй хэсэг болно.

- 5.3 Энэхүү Гэрээний Хавсралт 1 буюу Үйл Ажиллагааны Дэлгэрэнгүй Төлөвлөгөө нь Талуудын харилцан тохиролцож хэрэгжүүлэхээр тодорхойлсон үйл ажиллагааны хамрах хүрээ, хариуцах Тал, хэрэгжүүлэх хугацаа зэргийг тусгасан бөгөөд бүх хавсралтууд нь тус Гэрээний салшгүй хэсэг байна.
- 5.4 Энэхүү Гэрээ нь бүх Талуудын ашиг сонирхолд нийцсэн бөгөөд Гэрээний хавсралтаар оруулсан үйл ажиллагааны хэрэгжилтийг амжилттай хангахад чиглэсэн Талуудын үүрэг амлалт мөн болно. Талууд нь Гэрээг хэрэгжүүлэхэд үнэнч шударгаар, идэвхитэй хамтран ажиллана.
- 5.5 Энэхүү Гэрээний Хавсралт 1-т заасан бүх үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж дууссаны дараа тус Гэрээ нь дуусгавар болно.
- 5.6 Талууд нь энэхүү Гэрээний Хавсралт 1-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ малчид болон бусад оролцогч талын оролцоог хангаж, зөвлөлдөж ажиллахыг чухалчилна.

VI. Талуудын хоорондын харилцаа холбоо

- 6.1 Энэхүү Гэрээг хэрэгжүүлэхэд ГТЗ нь өөрийн Дүрмийн хүрээнд⁵ холбогдох талуудад нээлттэй харилцаа холбоог хангаж ажиллана. Гомдол гаргагчид нь зөвлөлийн дүрэмд заасны дагуу ГТЗ-ийн хуралд оролцож болох бөгөөд аливаа асуудлаар санал сэтгэгдлээ илэрхийлэх боломжтой байна.
- 6.2 Талууд энэхүү Гэрээг олон нийтэд илтөд, нээлттэй байлгахыг зөвшөөрөв.
- 6.3 Энэхүү Гэрээний хэрэгжилтийн талаар аливаа мэдээлэл, мэдэгдэл хийх тохиолдолд Талууд харилцан тохирсон, хамтарсан мэдэгдэл бэлтгэж ашиглахдаа ГТЗ-н дүрмийг баримтална.
- 6.4 Талууд нь энэхүү Гэрээний хэрэгжилтийн талаар үнэн бодит мэдээллийг оновчтой эх сурвалжаар дамжуулан цаг хугацаанд нь Ханбогд сумын малчид, иргэдэд хүргүүлэх замаар үүсч болзошгүй аливаа үл ойлголцол, ташаа мэдээллээс сэргийлж ажиллана.

VII. Мониторинг

- 7.1 Талууд тус Гэрээний хэрэгжилтийг гэрээнд гарын үсэг зурснаас хойш 12 сарын хугацаанд ЭЗХНЗОГ-ын үйл ажиллагааны журмын дагуу ЭЗХНЗОГ-аар мониторинг хийлгэнэ. Гэрээний хэрэгжилтийн мониторингийг утсаар эсвэл и-мэйлээр эсвэл харилцаа холбооны бусад хэлбэрээр буюу шаардлагатай тохиолдолд биечлэн танилцах замаар гүйцэтгэхийг зөвшөөрөв.
- 7.2 Дээр дурьдсан 7.1 заалтад тусгасан мониторинг хийх хугацааны төгсгөлд ЭЗХНЗОГ нь Гэрээ амжилттай хэрэгжиж байгаа эсэх талаар ГТЗ-ийн дүгнэлтэнд үндэслэн мониторингийн үнэлгээ, дүгнэлт гаргана. ЭЗХНЗОГ-ын дүгнэлтээр Гэрээг амжилттай хэрэгжиж байгаа гэж мониторингийн үнэлгээ, дүгнэлт гаргасан тохиолдолд Гомдлын Маргааныг хаана. Гэрээний хэрэгжилт амжилтгүй гэж мониторингийн үнэлгээ, дүгнэлт гаргасан тохиолдолд мониторингийн хугацааг сунгаж, Гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар ЭЗХНЗОГ-ын мониторингийг үргэлжлүүлнэ.
- 7.3 ЭЗХНЗОГ-ын мониторинг хийх явцад Талуудын хооронд энэхүү Гэрээтэй холбоотой аливаа маргаан эсвэл үл ойлголцол гарсан тохиолдолд

⁵ Гурван Талт Зөвлөл байгуулсан Харилцан Ойлголцлын Санамж Бичиг, ГТЗ-ийн дүрмийг үзнэ үү. http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/FinalSignedMoUwithAnnexures_MON.pdf

ЭЗХНЗОГ-ын эвлэрүүлэн зуучлалын багт аливаа Тал хандаж туслалцаа хүсч болно. Энэ тохиолдолд ЭЗХНЗОГ-ын эвлэрүүлэн зуучлалын баг тухайн маргаан эсвэл үл ойлголцлыг шийдвэрлэхийн тулд Талуудын уулзалтыг зохион байгуулж чиглүүлэн ажиллана.

- 7.4 Гомдлыг хаасны дараа ГТЗ нь малчид, бэлчээр, ус болон холбогдох бусад асуудал, гомдол, санал санаачлага эсхүл зөвлөмжүүдийг авч үзэх, анхаарал хандуулах, шийдвэрлэх, тэдгээрийн талаар мэдээлэл солилцох, тэдгээрт холбогдуулан санал, зөвлөмжүүд гаргах, түүнийг хэрэгжүүлэх, зохих эрх бүхий байгууллагуудад уламжлах чиг үүрэгтэй үргэлжлүүлэн ажиллана.⁶

VIII. Бусад

- 8.1 Гэрээг Монгол болон Англи хэл дээр тус бүр дөрвөн хувь үйлдэж хувийг Талуудад болон ЭЗХНЗОГ-д тус тус хүргүүлнэ.
- 8.2 Гэрээний англи хувь болон монгол эхийн хооронд зөрүү гарвал Гэрээний монгол эхийг баримтална.
- 8.3 Гэрээний гарчигуудыг Талууд гэрээний заалтыг ойлгох, хэрэглэхэд хялбар дөхөм байх үүднээс ашигласан бөгөөд Гэрээг тайлбарлахад аливаа нөлөө үзүүлэхгүй.
- 8.4 Гэрээг хэрэгжүүлэх явцад талуудын хооронд энэхүү Гэрээтэй холбоотой үл ойлголцол маргаан үүссэн тохиолдолд Талууд эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Эв зүйгээр тохиролцож чадаагүй тохиолдолд шүүхийн болон шүүхийн бус маргаан шийдвэрлэх хэрэгсэлд хандаж болно.

Талууд зөвшөөрч 2017 оны 5-р сарын 9-ний өдөр гарын үсэг зурав.

Ханбогд Сумыг төлөөлөн:

Ханбогд Сумын Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын Дарга

Ханбогд Сумын Засаг Дарга

Ханбогд Сумын Засаг Даргын Орлогч

Мал Эмнэлэг, Уржлийн Тасгийн Дарга

Байгаль орчны Хяналтын Улсын
Байцаагч

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
төлөөлөгч


Баян багийн Засаг Дарга




⁶Турван Талт Зөвлөл байгуулсан Харилцан Ойлголцлын Санамж Бичгийг үзнэ үү. http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/FinalSignedMoUwithAnnexures_MON.pdf

Ханбогд сумын Малчдыг төлөөлөн:



Лхамдофровын Батцэнгэл ←


Өөлийн Батцогтох ←


Долгорсүрэнгийн Намсрай ←


Чулууны Намнансүрэн ←



Данзаншадэвийн Наранхүү ←


Ганжуурын Мягмар ←


Төмөрмөнхийн Насанбуян ←


Цэвэгдэлгэрийн Гүнсмаа ←


Оюу Толгой ХХК-г төлөөлөн:


Шуркагийн Байгалмаа ←


Оюу Толгой ХХК-ийн Орон Нутгийн Харилцаа хариуцсан Ерөнхий Менежер

Шуркагийн Байгалмаа

Оюу Толгой ХХК-ийн Орон Нутгийн Харилцаа, Түншлэл хариуцсан Менежер,


Осорпүрэвийн Цэрэннадмид ←


Оюу Толгой ХХК-ийн Байгаль Орчны асуудал хариуцсан Менежер


Нарангийн Эрдэнэбаяр ←

Оюу Толгой ХХК-ийн Хөдөлмөрийн Харилцаа хариуцсан Менежер


Лхаасүрэнгийн Мөнх-Оргил ←

Оюу Толгой ХХК-ийн Хангамжийн Хэлтсийн Менежер


Дэлгэрийн Амартүвшин ←

Оюу Толгой ХХК-ийн Орон Нутгийн Харилцааны Ажилтан


Сүхрагчаагийн Дорждэрэм ←

ЭЗХНЗОГ-ын эвлэрүүлэн зуунагч Батсайханы Нандинчимэг болон Болдбаатарын Очирбат  нар байлцав. 

Хавсралт 1. Гомдлыг (#1) шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэхээр тохирсон арга хэмжээнүүд

ӨМНӨГОВЬ АЙМАГ, ХАНБОГД СУМ						
ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛ - 2017 оны 5-р сарын 9						
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТӨЛӨВЛӨГӨӨ						
№	Хийгдэх үйл ажиллагаа	Хэрэгжих хугацаа	Хариуцах тал	Үр дүнгийн гүйцэтгэлийн үзүүлэлт (KPI)	Тайлбар	Төрийн бодлого, хэрэгжиж буй хөтөлбөртэй уялдан байдал
2012 оны 10-р сард гаргасан малчдын гомдлын асуудлыг шийдэхээр тохирсон ажлыг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөө						
I. Бэлчээртэй холбоотой асуудлыг шийдэхээр тохиролцсон байдал						
1.1	Сумын нутаг дэвсгэр дэхь алдагдсан бэлчээрийн бүст тохируулга хийхийн тулд бэлчээрийн тогтолцоог дахин боловсруулах	2017 оны 4-р улиралд	Ханбогд сумын Засаг захиргаа	Төлөвлөгөө боловсруулагдсан байх	Бэлчээрийн шинжилгээнд үндэслэн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулна	Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг жил бүр шинэчлэн боловсруулж ИТХ-аар батлуулж ажиллана
1.2	Малчид уламжлалт байдлаар нүүдэллэх, ус, бэлчээрийг чөлөөтэй хүртэх байдлыг дэмжиж, худаг, бэлчээрт малчид хориг тавьдагийг багасгах	2017 оны 3-р улиралд	Ханбогд сумын Засаг захиргаа	237 гэрээ байгуулагдсан байх	Төрийн өмчид бүртгэлтэй бүх уст цэгийн ашиглагчтай гэрээ байгуулж ашиглалтыг нээлттэй болгоно.	Өвөлжөөний бэлчээрийг малын хөлөөс чөлөөлөх асуудлыг эрх зүйн актаар зохицуулах, Уст цэгийн ашиглагчийг шинэчлэн тогтоох.
1.3	Бэлчээрийн доорх усны нөөцийн судалгааны үр дүнд тулгуурлан худаг барих хөтөлбөрөөр дамжуулан шинэ бэлчээр нэмж бий болгох. Малчдын эзэмшлийн эрхийг тодорхой болгож, хэрэгжүүлэх	2018 онд	Ханбогд сумын Засаг захиргаа	Усжуулагдах боломжтой бүх нөөц бэлчээр усжуулагдсан байх	Инженерийн хийцэт уст цэгийг мэргэжлийн байгууллагаар, энгийн уурхайн худгийг сонирхлын бүлгээр гүйцэтгүүнэ.	Бэлчээрийн усны хайгуул хийснээр Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд бэлчээрийн усжуулалтын бодлого хэрэгжүүлнэ.
1.4	Улсаас үндэсний шинжээчид томилж өгөх, сургалт явуулах зэргээр орой нутгийн захиргаанд дэмжлэг үзүүлэх; энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд малчид, орон нутгийн байгууллагууд, бүх түвшний засаг захиргаа (баг, сум, аймаг, холбогдох мэргэжлийн байгууллагууд) санаачлагыг гартаа авч, бүгд хүчин чармайлт гаргах	2017 оны 3-р улиралд	Ханбогд сумын Засаг захиргаа	Бэлчээрийн чиглэлээр 5 мэргэжилтэн сургалтанд хамрагдсан байх	Бэлчээрийн шинжилгээний үр дүнд цуглуулсан мэдээллийг боловсруулдаг сургалтанд мэргэжилтнүүдийг хамруулна.	Мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.
1.5	ГТЗ нь хамааралтай талуудыг татан оролцуулахад идэвхтэй оролцож малчдад холбогдох туслалцаа үзүүлэхэд ГТЗ-өөс гадуур идэвхтэй үүрэг гүйцэтгэх: Талууд одоо үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд, орон нутгийн иргэдийн болон засаг захиргааны бүтцийн газрууд (жнь: багийн иргэдийн нийтийн хурал, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, мал аж ахуйн тасаг, газар ашиглалтын жилийн төлөвлөгөө боловсруулах үйл явц) зэрэг Сумын хөгжил цэцэглэлтэнд чухал үүрэгтэй болохыг хүлээн зөвшөөрөх. Тухайлбал сумын засаг захиргаа малчдад газар, устай холбоотой маргаантай асуудлыг шийдвэрлэж ирсэн уламжлалт арга барилаа сэргээх эсвэл бэхжүүлэн хэрэглэх замаар ОТ-той хамааралгүй мал маллагаанд холбоотой асуудлаа хэрхэн шийдвэрлэж болох талаар бодолцоход туслаж дэмжих	2017 оны 3-р улиралд	Ханбогд сумын Засаг захиргаа	Засаг даргын захирамжийг малчид дагаж мөрдүүлэх арга хэмжээ авсан байх, БИН-ийн хурлаар захирамжийг сайтар танилцуулсан, захирамжид малчдыг хариуцлагатай болгох зүйл заалт оруулсан байх		

Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ #1

1.6	Газрын Харилцаа, Геодези, Зураг Зүйн Газраас (ГХГЗЗГ) нөөц ашиглалт, нөөцийн эрхийг тодорхойлох, газар болон нөөц ашиглалтыг төлөвлөх ажлыг хэрэгжүүлэхэд нь хамтран ажиллах	2018	Ханбогд сумын Засаг захиргаа	Малчдад бууцны кадастрын зураг хийлгэх ойлголт, мэдээлэл өгөх, компанит ажил зохион байгуулсан байх	Малчид өөрсдөө бууцны кадастрын зураг хийлгэх мэдээллийг сайжруулах, компанит ажил зохион байгуулсан байх	
1.7	Малын тооны өсөлт, тавиул малын эзэн хэн болохыг тогтоох илүү дэлгэрэнгүй судалгаа шинжилгээ Ханбогд суманд хийх	2017 оны 4-р улиралд	Ханбогд сумын Засаг захиргаа	Мал бүхий иргэдийн судалгаа бүрэн гарсан байх	Мал бүхий иргэдийн мал сүрэг хэнийд маллагдаж байгаа нь тодорхой байгаа	
1.8	Хөдөлгөөний хурдыг багасгахын тулд ОТ-ХБ-н зам дээрх малын гарамуудын хоёр талд нь хурд сааруулагч хийх шийдвэр гаргахад Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтрах. Үүнийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд сумын Замын Цагдаагийн Газартай зөвлөлдөн хийнэ.	2018 онд	ОТ/Ханбогд сумын Засаг захиргаа	Холбогдох шийдвэр бичгээр гарсан байх		
1.9	ОТ нь бэлчээрийн боломжийг түргэн нэмэгдүүлэхийн тулд дор дурдсан болон тэдгээрээр хязгаарлахгүйгээр аливаа эвдсэн/орхисон газруудаа (Хавсралт А) аль болох хурдан нөхөн сэргээх, эвдэгдсэн газраас тоос босох хугацааг богиносгох, хуучин буюу ашиглаж буй карьерууд дээр гарах ослын эрсдэлийг бууруулах	2017-2027 (үе шаттайгаар)	ОТ	1) Биологийн нөхөн сэргээлт бүрэн хийгдсэн тухай Аймгийн Уул уурхайн ашиглалт, дэд бүтэц, бусад үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг хүлээн авах ажлын хэсгийн акт 2) одоо ашиглаж буй карьерууд дээр гарах ослын эрсдлийг бууруулах арга хэмжээ авсан байх (хашаа, тэмдэг тэмдэглэгээ гэх мэт)		Жил жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд оруулж баталгаажуулан ГТЗ-д танилцуулж ажиллана.
1.10	ОТ-н уурхайн үйлдвэрлэлийн хашаалсан талбайн тодорхой хэсэгт мал бэлчээрлүүлэх зохицуулалт хийх зорилго бүхий 2015 оны 3-р сарын 20-нд батлагдсан Уурхайн хашаалсан талбайд түр хугацаагаар мал бэлчээрлүүлэх журмыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;	Цаг хүндэрсэн үед хүсэлтээр	ОТ	Журмыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй Малчдын Төлөөлөгчдийн (МТБ)-н нотолгоо	Уулын ажлын төлөвлөгөөнөөс хамаарч тухайн бэлчээрийг ашиглах боломжгүй болох магадлалтай.	

II. Устай холбоотой асуудлыг шийдэхээр тохиролцсон байдал

2.1	ОТ-н усны төлбөрийн 50%-ийг сумын төсөвт эргүүлэн хуваарилах талаарх хүсэлтийг аймгийн ИТХ-д хандаж гаргах, хүсэлт илгээх;	2017 оны 3-р улиралд	Ханбогд сумын Засаг захиргаа	Аймгийн ИТХ-д хандаж гаргасан хүсэлт, хариу	Аймгийн ИТХ-д албан хүсэлт илгээх	
2.2	Гүехэн гар худгууд барих хөтөлбөрийн хэлбэрээр нийтийн нөхөн олговор олгох; малчид нүүдлээ хийн, бэлчээрийн нөөцийг ашиглахыг дэмжин, малчдад уламжлалт амьжиргаагаа үргэлжлүүлэн эрхлэх хэвээр үлдээхийн тулд худгуудыг 4 багийн нутагт тараан байрлуулах. Шинэ худгуудыг бүтээмж сайтай, одоо байгаа худгуудад нөлөөлөхгүй байлгахын тулд тэдгээрийн байршлыг бэлчээрийн доорх усны нөөцийн судалгаанд үндэслэн гаргах шаардлагатай ба түүнчлэн зэрлэг амьтдад нөлөөлөл учруулах эсвэл тэднээс ирэх нөлөөллийн тухайд малчид санаа зовдог гэх мэт малчдын санаа бодлыг тусгах хэрэгтэй;	Бэлчээрийн н доорх усны нөөцийн судалгааны дараа буюу шинэ худгийн хөтөлбөр 2018 оноос эхлэх	ОТ/ГТЗ	Бэлчээрийн доорх усны нөөцийн судалгаанд үндэслэн ГТЗ-ийн тохиролцож шинээр гаргасан худгийн тоо ...	Ажлын даалгаврыг ГТЗ-өөр хэлэлцүүлэх	Бэлчээрийн доорх усны нөөцийн судалгаа, бэлчээрийн төлөвлөгөө, Сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөө, Ханбогд сумын засаг даргын чиглэл
2.3	Ханбогд сумтай хамтран одоо байгаа малчдын худгууд болон шинээр баригдсан худгуудад засвар үйлчилгээ хийх малчдын баг байгуулах (хагас цагийн болон орон тооны ажилчдаас холимог бүрдсэн байвал зүгээр), сайн тогтолцоог бий болгох	2017 оны 4-р улиралд	ОТ/ГТЗ	Сумын бэлчээрийн уст цэгийг сэргээн засварласан үр дүн (бусад тайлан мэдээ)		Тогтвортой амьжиргаа хөтөлбөрт тусгагдсан нэг төсөл

⁷ Уурхайн хашаалсан талбайд түр хугацаагаар мал бэлчээрлүүлэх журмын дэлгэрэнгүй үзнэ үү. http://www.caombudsman.org/cases/document-links/documents/FinalGrazingAccessProtocol_MON_March20-2015.pdf

Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ #1

2.4	2.2-т заасан бэлчээрийн усны нөөцийн гидрологийн судалгааны үр дүнд шинээр худаг гаргаж шийдэсний дараа одоо ус зөөж байгаа түр зуурын арга хэмжээг үе шаттай зогсоох	Бэлчээрийн доорх усны нөөцийн судалгааны дараа буюу шинэ худгийн хөтөлбөр 2018 оноос эхлэх	ОТ	Түр зуурын арга хэмжээг зогсоосон байдал	
2.5	Гүний хоолой орчмын гоожиж буй бүх цооногуудыг бөглөж, Багийн Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцэж ирүүлсэн малчдын хүсэлтэнд тулгуурлан оргиж буй 2 цооног малчдад ахуйн зориулалтаар ашиглуулах	2016	ОТ/Ханбогд сум	Оргиж буй 2 цооногийг орон нутгийн ажлын хэсгийн хүлээн авсан акт	
2.6	Гүний хоолой, Галбын говь дахь ОТ-н усны хайгуулын цооногуудаас орон нутгийн малчдын бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар ашиглах боломжтой 12 цооногийг Ханбогд суманд хүлээлгэж өгөх	2017 оны 3-р улирал	ОТ/Ханбогд сум	Цооногуудыг орон нутгийн ажлын хэсгийн хүлээн авсан акт	
2.7	Гидрогеологийн судалгаа (бэлчээрийн доорх усны нөөцийн судалгааг) санхүүжүүлж мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	2017 оны 2-3-р улиралд	ОТ/ Ханбогд сум	Сумын нийт газар нутаг дахь бэлчээрийн усны нөөцийг тогтоосон зураглал (бусад тайлан мэдээ)	Уг судалгаа нь худаг барих хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэс суурийг бий болгоно. Судалгааны ажлын даалгаврыг ГТЗ хэлэлцүүлнэ.

III. Мониторинг, тайлагналт, орон нутгийн харилцаатай холбоотой асуудлыг шийдэхээр тохиролцсон байдал

3.1	Одоогийн гэрээлж байгаа мониторингийг үе шаттайгаар орон нутгийн мониторингоор солих бодлого баримталж, орон нутгийн мэргэшсэн байгууллага, малчдыг мэргэжлийн мониторинг хийх түвшинд чадавхжуулах; Малчид чин сэтгэлээсээ оролцож, хариуцлагатай хандах нь мониторингийг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэхэд зайлшгүй чухал, иймд мониторингийн ажлыг цалин урамшуулалтай болгох; Оролцоог хангахын тулд хөтөлбөрүүд мал маллагааны хэв маягт тохирсон, малчид хянан баталгаажуулах боломжтой, шинжлэх ухааны үндэслэлтэй, итгэл үнэмшлийг хангасан, хүртээлтэй, найдвартай байлгахын тулд баримт хамтран олж тогтоох аргачлалыг ашиглан боловсруулж, хэрэгжүүлэх.	2018 оны 1-р сараас эхлэх	ОТ С. Дорждэрэм, ОТ Б. Алтангэрэл, ОНЗЗ Д. Намсрай, МТ	1. Малчдын бүлэгтэй хамтын мониторинг хийлгэх гэрээ байгуулж ажиллаж эхэлсэн байх 2. ОТ-н дахин боловсруулсан	1. Зөвхөн нэг малчдын бүлэгтэй гэрээ байгуулах бөгөөд малчдын бүлэг нь дотроо тодорхой төрлүүдээр мониторинг хийх дэд бүлгүүдэд хуваагдсан байж болно. 2. Урт хугацаанд (ажлын төлөвлөгөөнд тодорхойлох)
3.1.1	Орон нутгийн мониторингийн зорилго болон хамрах хүрээ, төрийг тохирох (бэлчээр, хөрс, ургамалжилт, ус, тоос, зэрдэг ан амьтан, Ундайн гол, Халив Дугатын голын урсац, Хаягдал Хадгалах Байгууламжийн шүүрэл, урсацын доод тал руу гарч болзошгүй нөлөөлөл гэх мэт)	2017 оны 4-р улиралд		ГТЗ-өөр дэмжсэн байгаль орчны мониторингийн хөтөлбөр, (хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн явцын тайлан)	мониторингийн дата мэдээлэлд шинжилгээ хийн зөвлөмж боловсруулах чадварыг бэхжүүлэх, энэ чиглэлээр мэргэшсэн хүн бэлтгэхэд зорих
3.1.2	Мониторингийн ажлын төлөвлөгөө (аргачлал) боловсруулж ГТЗ-д танилцуулах				
3.1.3	Мониторингийн мэдээ цуглуулах, боловсруулах, тайлагнах талаар малчдын бүлгийг сургаж чадавхжуулах	2017 оны 4-р улиралд эхлэх			
3.1.4	Мониторингийн ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж ажиллах	2018 оны 1-р сараас эхлэх			
3.1.5	Байгаль орчны мониторингийн үр дүн, түүний үндсэн дээр авсан эсвэл санал болгосон аливаа арга хэмжээг малчид, орон нутгийн иргэдэд тогтмол тайлагнан танилцуулах; Мэдээлэл шууд, ойлгомжтой, малчидтай холбоотой; сумд өгөх тайлангууд мэргэжилтнүүдэд ойлгогдохоор байх шаардлагатай. Олж тогтоосон зүйлсийн	Мониторингийн ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгах	ОТ/Малчдын бүлэг	Нийтэд танилцуулсан мониторингийн үр дүн, тайлан мэдээлэл	

Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ #1

	талаар бүх багийн төв, сумын төв дээр танилцуулж байх;					
3.2	Хөөн хэлэлцүүлж байгаа нөхөн олговрын хэрэгжилт, ахицад мониторинг хийж, улирал тутам ГТЗ-д танилцуулна. Үүнд: Нэхэмжлэлийн Хороонд ирсэн өргөдлүүд; хүлээн зөвшөөрсөн эсвэл татгалзсан хариу, татгалзах болсон шалтгаан, тохиролцоонд хүрсэн нөхөн олговрын гэрээ; олгосон нөхөн олговор зэрэг орно.	Улирал бүр	ОТ	Энэ тухай улирал тутмын тайлан танилцуулга, ГТЗ болон малчдад танилцуулсан байдал		
3.3	Өнгөрсөн оныхоо гүйцэтгэл, ирэх оны төлөвлөгөө, орон нутгийн эдийн засагт үзүүлсэн нөлөөлөл, ажил олголт, орон нутагт төлсөн татвар, хураамж, орон нутгийн худалдан авалт; байгаль орчны нөлөөлөл, байгаль орчны нөлөөллийн мониторинг ба менежментийн хөтөлбөрүүд, холбогдох тоо баримт; нийгмийн гүйцэтгэл, нөхөн олговрын хөтөлбөр, эмзэг хүмүүст тусалсан байдал, сургалт, бизнес эрхлэлт, Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд санхүүжүүлсэн төслүүд, хандив зэргийг хамарсан мэдээллийг жил бүр Ханбогд суманд гаргаж өгөх ба үүнийг Монгол хэлээр, малчид, ард иргэдэд хүртээлтэй хэлбэрээр гаргах;	Жил бүр	ОТ/Ханбогд сумын засаг захиргаа	Монгол хэлээр малчид, ард иргэдэд хүртээлтэй хэлбэрээр Ханбогд суманд гаргаж өгсөн мэдээлэл (хамтарч мэдээллийг бэлтгэсэн байх)		
3.4	Орон нутгийн харилцааны ажлыг өргөжүүлэх. Багийг ОТ ба малчдын (мөн орон нутгийн бусад иргэдийн) хооронд хоёр талын үр дүнтэй харилцаа бий болгох үүрэг бүхий, бэлтгэгдсэн хүмүүсээс бүрдүүлэх. Үүнд мөн албан ёсны уулзалтуудад оролцох, жишээ нь багийн хуралд суух, орон нутгийн захиргаа болон сонгогдсон албан тушаалтнуудтай ойр холбоотой байх; Түүнчлэн 'эмзэг' гэж тогтоогдсон хүмүүс гэх мэт явагдаж буй нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдсан хүмүүстэй байнгын холбоотой байх, цаг зав гарган сумын хэмжээгээр явж, хүмүүстэй нээлттэй найрсаг, сайн харилцаа тогтоох гэх мэт; ОТ-н үйл ажиллагааны талаар цаг үеийн мэдээллийг (ялангуяа барилгын ажлын үеэр, Уурхайн Лицензтэй Талбай (УЛТ)-н гадна ажиллаж буй гэрээт байгууллагуудын үйл ажиллагаа, хэн хаана юуг хэдий хугацаагаар хийж буй, хүмүүсийг ажилд яаж авч байгаа гэх мэт) малчид, орон нутгийн бусад иргэдэд хүргэх, мэдээллийг удирдлагадаа танилцуулж байхын тулд орон нутгийн харилцааны ажилтнууд ОТ компани дотроо маш сайн харилцаа холбоотой байна;	Тайлан улирал бүр Малчин өрхөөр орж ажиллах жил бүр	ОТ	1. Багийн иргэдийн нийтийн хуралд ОТ-н орон нутгийн харилцааны ажилтнууд оролцож бодит мэдээлэл өгсөн байдал, 2. Баг тус бүрийн нийт малчин өрхийн 50%-с доошгүй малчин өрхөд орж ажилласан жилийн тайлан 3. Малчдын гомдол хүсэлтийг шийдсэн байдал	Малчин өрхүүдээр орохдоо бүх багийн малчин өрхийг хамруулахад анхаарах	
3.5	ОТ-н гомдлыг барагдуулах механизмыг сайжруулах. ГТЗ-ийн бусад гишүүдтэй хамтран хөндлөнгийн этгээдэд хандах тухай хувилбарыг тодорхой болгоно. Одоо ашиглаж буй гомдлыг барагдуулах механизмын талаар малчид, орон нутгийн бусад иргэдэд танилцуулж, зөвлөлдөн зөвлөлдөөнөөр гарсан саналд үндэслэн; шаардлагатай бол засаж залруулах. Өөрчилсөн зүйлсийн талаар үр дүнтэйгээр нийтэд мэдээлэн, ОТ-н талаар гомдолтой иргэдийг тус механизмыг ашиглахыг хөхүүлэх	2017 оны 2-р улиралд	ОТ	Сайжруулан боловсруулсан гомдлыг барагдуулах механизм (өмнөх механизмтай харьцуулах)	ОТ гомдлыг барагдуулах журмаа сайжруулан боловсруулсан бөгөөд ГТЗ-өөр хэлэлцүүлэх	
IV. Нөхөн олговортой холбоотой асуудлыг шийдэхээр тохиролцсон байдал						

Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ #1

4.1	Айванхо Майнс Монголиа Инк (АММИ)-н 2004 оны нүүлгэн шилжүүлэлтэнд хэрэглэсэн арга барил нь ялангуяа харилцаа холбооны тухайд асуудалтай байсныг ОТ малчдын өмнө хүлээн зөвшөөрч 2004 онд нүүлгэн шилжүүлсэн өрхүүдийн асуудлыг шийдэхийн тулд ГТЗ-ийн хүрээнд хамтран ажиллах;	2017 оны 3-р сарын 22	ОТ	ГТЗ-ийн 2017 оны 3-р сарын 22-ны өдрийн Хамтарсан Мэдэгдэл энэ гэрээний тухайд хангалттай байх болно.	
4.2	ГТЗ нь хөндлөнгийн бие даасан нарийн бичгийн даргын тусламжтай ажиллаж болох бөгөөд, 2004, 2011 оны хөтөлбөрийн дагуу малчид нөхөн олговор авах шалгуурыг хангасан эсэхийг шийдвэрлэх "Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хороо"-ны үүрэг гүйцэтгэж ажиллана.	2017 оны 3-р улиралд	Нэхэмжлэлийн хороо	1. Нэхэмжлэлийн Хорооны хуралд ЭЗХНЗОГ-ын эвлэрүүлэн зуучлагч, чиглүүлэгч сууж ажиглах, 2. Нэхэмжлэлийн Хорооны журам	
4.3	Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хорооны үйл ажиллагааны журмыг хамтран боловсруулж ашиглах	2017 оны 2-р улиралд	Гурван талт зөвлөл	Нэхэмжлэлийн Хорооны журам	
4.4	Дараах шалгуур хангасан малчин өрхүүдэд 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийн гэрээнд хөөн хэлэлцүүлж орох хүсэлтээ нөхөн олговрын нэхэмжлэлийн хороонд тавих боломж олгох:	2017 оны 3-р улиралд эхлэх	Нэхэмжлэлийн хороо	Нэхэмжлэлийн хороонд ирүүлсэн хүсэлтийг шалгуурын дагуу шийдсэн байдал	
4.4.1	2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн заасан бүсэд тухайн үед өвөлжөө, хаваржааны байгууламжтай байсан, 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн ямар ч гэрээгүй өрхүүд				
4.4.2	Нэг өвөлжөө хуваан эзэмшиж байсан, нүүлгэн шилжүүлэлтийн ямарч гэрээгүй малчин өрх буюу тухайн үед тус тусдаа малчин өрхийн бүртгэлтэй байсан өрхүүд				
4.5	2004 онд нүүлгэн шилжүүлэлтэнд хамрагдсан 10 өрхийн хувьд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх:	2017 оны 2-р улиралд эхлэх	ОТ	1. Амьжиргааг дэмжих тэтгэлэгтэй сургалтанд нэмж 2 хүнийг хамруулсан байдал, 2. Тогтвортой амьжиргааны хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байх	
4.5.1	2004 оны нүүлгэн шилжүүлсэн өрхөөс ажлын байргүй байгаа 2 өрхийг Амьжиргааг дэмжих тэтгэлэгтэй сургалтанд нэг жилийн хугацаанд хамруулах				
4.5.2	2004 онд нүүлгэн шилжүүлсэн 10 өрхийг тогтвортой амьжиргааны хөтөлбөрт (Энэ төлөвлөгөөний 4.10.4) хамруулах				
4.6	2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн заасан бүсэд өвөлжөө, хаваржаатай байсан, 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртөж нөхөн олговор авах нэхэмжлэлийг хөөн хэлэлцүүлж шалгуурыг хангасан малчдад 2004 онд олгож байсан нөхөн олговрын хэмжээтэй дүйцэхүйц эсвэл тухайн багцаас бууруулахгүй нөхөн олговор олгох	2017 оны 3-р улиралд эхлэх	ОТ	Нэхэмжлэлийн хороонд ирүүлсэн хүсэлтийг шалгуурын дагуу шийдсэн байдал	Нэхэмжлэлийн Хорооны журамд нөхөн олговрын багцыг тодорхой заах
	2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн заасан бүсэд өвөлжөө хуваан эзэмшиж байсан, 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртөж нөхөн олговор авах нэхэмжлэлийг хөөн хэлэлцүүлж шалгуурыг хангасан малчдад Нэхэмжлэлийн Хорооны журамд заасны дагуу нөхөн олговор олгох				
4.7	2011 оны нөхөн олговор аваагүй, дараах шалгуур хангасан малчин өрхүүдэд нөхөн олговор олгох	2017 оны 3-р улиралд эхлэх	Нэхэмжлэлийн хороо	Нэхэмжлэлийн хороонд ирүүлсэн хүсэлтийг шалгуурын дагуу шийдсэн байдал	Хам өрхийн хоорондын нөхөн олговрын холбоотой маргаан нь ГТЗ болон Нэхэмжлэлийн Хороонд хамааралгүй.
4.8	2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийн заасан бүсэд тухайн үед өвөлжөө, хаваржааны байгууламжтай байсан, 2011 оны нөхөн олговрын ямар ч гэрээгүй, нөхөн олговор авах нэхэмжлэлийг хөөн хэлэлцүүлж шалгуурыг хангасан малчдад 2011 онд олгож байсан нөхөн олговрын хэмжээтэй дүйцэхүйц эсвэл тухайн багцаас бууруулахгүй нөхөн олговор олгох				
4.8.1	2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийн заасан бүсэд тухайн үед өвөлжөө, хаваржааны байгууламжтай байсан, 2011 оны нөхөн олговрын ямар ч гэрээгүй, нөхөн олговор авах нэхэмжлэлийг хөөн хэлэлцүүлж шалгуурыг хангасан малчдад 2011 онд олгож байсан нөхөн олговрын хэмжээтэй дүйцэхүйц эсвэл тухайн багцаас бууруулахгүй нөхөн олговор олгох				Нэхэмжлэлийн Хорооны журамд нөхөн олговрын багцыг тодорхой заах

Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ #1

4.8.2	Нэг өвөлжөө хуваан эзэмшиж байсан, нөхөн олговрын ямарч гэрээгүй малчин өрх буюу тухайн үед тус тусдаа малчин өрхийн бүртгэлтэй байсан өрхүүдийн нэхэмжлэлийг хөөн хэлэлцүүлж шалгуурыг хангасан малчдад 2011 онд олгож байсан нөхөн олговрын хэмжээтэй дүйцэхүйц эсвэл тухайн багцаас бууруулахгүй нөхөн олговор олгох				Хам өрхийн хоорондын нөхөн олговрын холбоотой маргаан нь ГТЗ болон Нэхэмжлэлийн Хороонд хамааралгүй.
4.9	2011 онд нөхөн олговор авсан 89 өрхийн хувьд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх				
4.9.1	2011 оны нөхөн олговрын гэрээний 1) Үр дүнгийн үнэлгээ, 2) Хэрэгжилтийн аудитыг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх;	2017 онд багтааж Үр дүнгийн үнэлгээг дуусгах	ОТ	Нөхөн олговрын гэрээний Үр дүнгийн хөндлөнгийн үнэлгээний тайлан, цаашид авахаар тохирсон арга хэмжээ	Үр дүнгийн үнэлгээний дүгнэлтэнд тулгуурлан цаашид авах арга хэмжээ болон Хэрэгжилтийн аудитыг хийлгэх хугацаа, хүрээг ГТЗ-өөр дахин хэлэлцэх
4.9.2	Үр дүнгийн үнэлгээний дүгнэлтийг харгалзаж 2011 оны нөхөн олговрын гэрээнийг дуусгавар болгох эсвэл цаашид арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг ГТЗ/Нөхөн олговрын ажлын хэсэг шийдвэрлэх;				
4.9.3	Нөхөн олговроо гүйцэд аваагүй эсвэл ямар нэгэн гомдол санал гаргасан өрхүүдийн асуудлыг Нэхэмжлэлийн Хороогоор хянан шийдвэрлэх;				
4.9.4	Талууд харилцан зөвшөөрснөөр 2004 ба 2011 оны нөхөн олговрын гэрээний нууцлалыг хадгалах тухай зүйл заалтыг цуцалж иргэд нөхөн олговрын талаарх мэдээллээ бусдад ил болгохыг хүсвэл энэ боломжийг нээлттэй болгох	2017 оны 3-р сарын 22	ГТЗ	ГТЗ-ийн 2017 оны 3-р сарын 22-ны өдрийн хурлын тэмдэглэл нь энэ заалтын тухайд хангалттай хэрэгжсэн гэж үзэх	
4.10	Ханбогд сумын бүх малчин өрхүүдэд нийтийн нөхөн олговрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх		ОТ	2004, 2011 оны нөлөөллийн бүсийн дөнгөж гадна үлдсэн өрхүүд, шууд бус нөлөөлд өртсөн малчин өрхүүдийг "зорилтот бүлэг" гэх бөгөөд нийтийн нөхөн олговрын хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаанд давуу боломж олгох;	
4.10.1	Ханбогд сумын бүх малчин өрхүүдэд нийтийн нөхөн олговор байдлаар урт хугацаанд ХБ сумын 2024 он хүртэлх МААХХ, Хамтын Ажиллагааны гэрээний хүрээнд ОТ-н Говийн Оюу Сангаас санхүүжүүлэх урт хугацааны төслүүдийг хэрэгжүүлэх (Хавсралт Б)	2017-2024	ОТ / Ханбогд сумын засаг захиргаа	МААХХ-ийн хүрээнд хэрэгжүүлэх томоохон төслүүд хэрэгжиж эхлэсэн байх	Хавсралт Б
4.10.2	Магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуульд суралцаж буй малчдын оюутан хүүхдүүдийн сургалтын тэтгэлэг олгох – (тохиролцоонд хүрсэн өдрийн байдлаар оюутан байгаа хүүхдүүдийг нь төгсгөл олгох) – Ингэхдээ голч оноо нь 2.7-оос дээш; Сум орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлийн суралцаж буй малчдын оюутан хүүхдүүдэд олгох		ОТ		
4.10.2.1	Малчдын оюутан хүүхдүүдэд сургалтын тэтгэлэг олгох хөтөлбөр (шалгуур үзүүлэлт, суралцах чиглэл, тэтгэлгийн дээд хэмжээ гэх мэт,) боловсруулж ГТЗ-г танилцуулан дэмжүүлэх	2017 оны 6-7-р сард	О. Цэрэннадмид, ОТ	Тэтгэлэг олгох хөтөлбөрийн шалгуур хангасан малчдын бүх оюутан хүүхдүүдэд сургалтын тэтгэлгийг олгож эхлэсэн байх	Сум орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлийн талаар сумын ИТХ-н тэргүүлэгч гишүүд хэлэлцэж шийдвэр гарган Нэхэмжлэлийн Хороонд өгөх
4.10.2.2	Тэтгэлэгт хамрагдах малчдын хүүхдийн нэрсийн жагсаалт, суралцаж буй сургуулийн нэр, суралцаж буй мэргэжлийн чиглэл, сурч буй түвшин, сурлагын голч онооны жагсаалт мэдээллийг гаргах	2017 оны 6-р сар	Ч. Намнансүрэн, Д. Намсрай, Ө. Баттогтох, Л. Батцэнгэл, Т. Насанбуян МТ, Б. Эрдэнэбаяр, ОНЗЗ		
4.10.2.3	Тэтгэлэгт хамрагдах хүсэлт хүлээн авч шийдвэрлэж эхлэх	2017 оны 8-р сараас эхлэх	О. Цэрэннадмид, ОТ		

Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ #1

4.10.3	3.1-т заасантай уялдуулан мониторингийн ажлыг цалин урамшуулалтай болгох (бүлгийн зохион байгуулалтанд оруулж, гэрээ байгуулж ажиллахаар зохион байгуулах)	2018 оны 1-р сараас эхлэх	С. Дорждэрэм, ОТ Б. Алтангэрэл, ОНЗЗ Д. Намсрай, МТ	Малчдын бүлэгтэй хамтын мониторинг хийлгэх гэрээ байгуулж ажиллаж эхэлсэн байх	1. Зөвхөн нэг малчдын бүлэгтэй гэрээ байгуулах бөгөөд малчдын бүлэг нь дотроо тодорхой төрлүүдээр мониторинг хийх дэд бүлгүүдэд хуваагдсан байж болно. 2. Урт хугацаанд мониторингийн дата мэдээлэлд шинжилгээ хийн зөвлөмж боловсруулах чадварыг бэхжүүлэх, энэ чиглэлээр мэргэшсэн хүн бэлтгэхэд зорих
4.10.4	Тогтвортой Амьжиргааны Хөтөлбөр хамтран боловсруулж хэрэгжүүлэх	2017-2024	ОТ/ГТЗ		ГТЗ нь жилд нэг удаа хөтөлбөрийн хэрэгжилт, цар хүрээ, үр дүнг хэлэлцэж, хэрэгцээнд тулгуурлан өөрчилж, нэмж сайжруулан боловсруулах, хамтарч ажиллах
4.10.4.1	Төсөл 1: Амьдрах ухааны цогц сургалтын төсөл			Төсөл 1 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)	
4.10.4.1.1	Сумын насан туршийн боловсролын төвтэй хамтран төслийн санал боловсруулан ГТЗ-д танилцуулах	2017 оны 3-р улирал	Занабазар, Засаг даргын орлогч Танхилдулам, ОТ		
4.10.4.1.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал	Ч. Намнансүрэн, МТ		
4.10.4.1.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал			
4.10.4.2	Төсөл 2: Худаг засварын баг байгуулах төсөл			Төсөл 2 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)	
4.10.4.2.1	Энгийн уурхайн болон инженерийн хийцтэй уст цэг засварладаг баг байгуулах төслийн санал боловсруулан ГТЗ-д танилцуулах (орон нутгийн малчид болон мэргэжлийн байгууллага хамтарсан баг)	2017 оны 3-р улирал	ОТ Сүлэгмаа, МЭҮТ Баярбаатар, ОТ Ө. Баттогтох, МТ		
4.10.4.2.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал	ОТ		
4.10.4.2.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал			
4.10.4.3	Төсөл 3: Хороо засварын баг байгуулж ажиллах төсөл			Төсөл 3 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)	
4.10.4.3.1	Орон нутгийн малчдаас бүрдсэн малын хороо барьж, засварлах баг байгуулах төслийн санал боловсруулан ГТЗ-д танилцуулах	2017 оны 3-р улирал	Хүрэлбаатар, МЭҮТ Баярбаатар, ОТ Г. Мягмар, МТ		
4.10.4.3.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал			
4.10.4.3.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал	ОТ		
4.10.4.4	Төсөл 4: Малчны зах байгуулах буюу Малын гаралтай түүхий эдийг үйлдвэрлэгчдэд ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход дэмжлэг үзүүлэх төсөл			Төсөл 4 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)	Сумын бизнес эрхлэгчидтэй хамтарч боловсруулах, хэрэгжүүлэх
4.10.4.4.1	Цогт-Цэций сум болон бусад сумдад байдаг малчны захын талаар судалж малын гаралтай түүхий эд бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчдэд хүргэх ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход дэмжлэг үзүүлэх төслийн санал боловсруулан ГТЗ-д танилцуулах		Занабазар, ОН Баярбаатар, ОТ Л. Батцэнгэл, МТ		
4.10.4.4.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал			
4.10.4.4.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал	ОТ		
4.10.4.5	Төсөл 5: Малчдад хүрэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах төсөл	2017 оны		Төсөл 5 хэрэгжиж	

Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ #1

4.10.4.5.1	Сум дундын эмнэлэгтэй хамтран одоо хэрэгжиж буй Эрүүл малчин төслийн үйл ажиллагааг өргөжүүлэн төслийн санал боловсруулж ГТЗ-д танилцуулах	10-р сар	Гэрэлмаа эмч, Сум дундын эмнэлэг Танхилдулам, ОТ Т. Насанбуян, МТ	эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)		
4.10.4.5.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал				
4.10.4.5.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 3-р улирал	ОТ			
4.10.4.6	Төсөл 6: Малын тэжээлийн ургамал тариалах төсөл					
4.10.4.6.1	Сумын хэмжээнд малын тэжээлийн ургамал тариалах төслийн санал боловсруулж ГТЗ-д танилцуулах (шаашид бие даан үйл ажиллагаа явуулах)	2017 оны 3-р улирал	Сүглэгмаа, МЭУТ Баярбаатар, ОТ Д. Намсрай, МТ	Төсөл 6 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)		
4.10.4.6.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх					
4.10.4.6.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал	ОТ			
4.10.4.7	Төсөл 7: Хиймэл нуур цөөрөм, хур борооны ус цуглуулах хөв байгуулах;					
4.10.4.7.1	Баг тус бүрээр хөв байгуулах боломжтой байршлуудыг тогтоож, сэргээн тохижуулах шаардлагатай цэгүүдийг малчдын санал дээр үндэслэн тогтоох	2017 оны 3-р улирал	Сумын засаг захиргаа, Багийн иргэдийн хурал Малчдын төлөөлөл	Төсөл 7 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)		
4.10.4.7.2	Тогтоосон цэгүүд дээр судалгаа хийж, сэргээн тохижуулах төлөвлөгөө гарган ГТЗ-д танилцуулах		Хүрэлбаатар, МЭУТ Баярбаатар, ОТ Т. Насанбуян			
4.10.4.7.3	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал				
4.10.4.7.4	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал	ОТ			
4.10.4.8	Төсөл 8: Малчдын хэрэглээний гүн өрмийг худгийг сэргээгдэх эрчим хүчинд холбоход дэмжлэг үзүүлэх;					
4.10.4.8.1	Тоноглох шаардлагатай гүн өрмийн худгуудын тоо, байршил тогтоож, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй холбох төслийн санал боловсруулан ГТЗ-д танилцуулах (хэрэглээ, ашиглагчийн байдал зэргийг харгалзана)	2017 оны 3-р улирал	Хүрэлбаатар, МҮЭТ Баярбаатар, ОТ Д. Наранхүү, МТ	Төсөл 8 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)		
4.10.4.8.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал				
4.10.4.8.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал	ОТ			
4.10.4.9	Төсөл 9: Залуу малчдад дэмжлэг туслалцаа үзүүлэх, "Залуу малчин" (35-аас доош насны) төсөл хэрэгжүүлэх (ХБ сумын 2024 он хүртэлх МААХХ-т тусгагдсан)					
4.10.4.9.1	Аймгийн малчин хөтөлбөртэй уялдан залуу малчдад хандсан сургалт, мэдээллийн төслийн санал боловсруулан ГТЗ-д танилцуулах	2017 оны 11-р сар	Хүрэлбаатар, МҮЭТ Баярбаатар, ОТ Ч. Намнансүрэн, МТ	Төсөл 9 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)		
4.10.4.9.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал				
4.10.4.9.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал	ОТ			
4.10.4.10	Төсөл 10: Мал нядалгааны шугам барих, байнгын ажиллагаатай болох					
4.10.4.10.1	Төслийн санал боловсруулан ГТЗ-д танилцуулах	2018	ОТ/Ханбогд сумын Засаг Захиргаа	Төсөл 10 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)	Тогтвортой Амьжиргаа Хөтөлбөрийн хүрээнд энэ төслийн	Хавсралт Б- 18-д заасан төсөл

Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ #1

4.10.4.10.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх			тайлан)	техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа хийх ажлыг оруулах
4.10.4.10.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх				
4.10.5	Малчид болон орон нутгийн иргэдийн ЖДБ-ыг чадавхжуулах сургалт явуулах, бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх жижиг зээл авах боломж олгох (ХААН БАНК-аар дамжуулан зээлийн хүсэлт тутамд 30 сая хүртэлх зээл олгохоор тохирсон)	2017 оны 4-р улиралд эхлэх	ОТ/Ханбогд сумын Засаг Захиргаа	1.Сургалтанд хамрагдсан малчны тоо, 2. Зээл авсан малчдын тоо	ХААН банк хэрэгжүүлж байгаа "Төслийн зээл" – шалгуурыг харьцуулж харах ОУСК-ийн шинээр хэрэгжүүлэх төсөлтэй уялдуулах
4.10.6	Ханбогд сумын төвийн сайжруулсан замыг хатуу хучилттай болгох, ХБ сумын цэвэр усан хангамж, бохир усны шугам суурилуулах зэрэг Малчдаас ирүүлсэн саналыг Өмнөговь аймгийн Ханбогд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах нэгж ХБ Хөгжлийн Хороонд уламжилж шийдүүлэх	2017 оны 4-р улирал	ОТ/Ханбогд сумын Засаг Захиргаа	Хөгжлийн хорооны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан байдал	
4.10.7	Ханбогд Сум харилцаа холбооны сүлжээний хамрагдалтыг нэмэгдүүлэхийн тулд Юнителийн сүлжээний антенныг Гавилууд багт байрлуулах ажлыг хэрэгжүүлэх	2017 оны 2-р улиралд	Ж. Занабазар, Ханбогд сумын Засаг захиргаа	Сүлжээнд холбогдсон байх	

ЭЦСКИЙН ХУВИЛБАР

Хавсралт А: Нөхөн сэргээлт хийх газруудын жагсаалт

1. Хуучин онгоцны буудал
2. ОТ-с баруун урагшаа сайжруулсан замын хэсэг - Хар Толгойн голын дээд болон доод хэсэг (газар дээр нь тодруулах)
3. ХБ-ын замын хойд талд байрлах карьер
4. УЛТ-н гадуур байсан кемпуудын нутаг
 - Хүрэн дэлийн бууцны зүүн талд А кемпийн нутаг
 - Гүний Хоолойн Усны кемпүүд
5. Цагаан хаднаас Гашуун Сухайтын хилийн боомт хүртэлх замд ашигласан карьер
6. ОТ-н УЛТ-н урд хаалганаас Жавхлант багийн төв хүртэлх хуучин зам болон зам дагуух кариерууд
7. ОТ-н УЛТ-н баруун шар хаалганаас нүүрсний зам хүртэлх хуучин ашиглаж байсан шороон замууд
8. ОТ-с Манлай хүртэлх сайжруулсан шороон замын хажуугийн салаа шороон замууд

Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ #1

Хавсралт Б: Нийтийн нөхөн олговрын хүрээнд ХБ сумын 2024 он хүртэлх МААХХ-ийн хүрээнд ОГ-н хамтын ажиллагааны гэрээний хүрээнд санхүүжүүлэхээр тохирсон урт хугацаанд хэрэгжүүлэх төслүүд

#	Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажил	Хэрэгжи х хугацаа	Удирдан зохион байгуулах газар	Хамтран зохион байгуулах	Төсөв, сая
Мал аж ахуйн салбарын хөгжлийн суурь болох бэлчээр, усны нөөцийн цогц судалгаа хийж тэдгээрт үндэслэн сумын бэлчээр ашигдалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх					
1	Бэлчээрийн даац, чанарын үнэлгээ хийх, тэжээлийн нөөц тодорхойлох, чадамжийг шинэчлэн тогтоох	2016-2017 он	Өмнөговь аймгийн ХХААГ	Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумдын ЗДТГ. Мэргэжлийн байгууллага	500.0
2	Сумын хэмжээнд уст цэгийн нэгдсэн тооллого хийж үнэлгээ өгөх, мэргэжлийн байгууллагаар гидрогеологийн хайгуул тандалт хийлгэж нөөц тогтоолох;	2016-2017 он	Өмнөговь аймгийн ХХААГ	Ханбогд сумын ЗДТГ. Мэргэжлийн байгууллага	900.0
3	Малын тэжээлийн нэгдсэн агуулахтай болж, нөөц бий болгох, мал сүргийг эрдлээс хамгаалах сан бүрдүүлэх	2018-2020 он	Ханбогд сумын ЗДТГ.	Аймгийн онцгой байдлын газар	300.0
4	Усны нөөцийн судалгааг үндэслэн шинээр худал гаргах, уст цэгийг сэргээн засварлах;	2019-2022 он	Ханбогд сумын ЗДТГ.	Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумдын ЗДТГ. Мэргэжлийн компани	500.0
Малын эрүүл мэндийн нэгдсэн төвийг байгуулж, мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, шийрэгжүүлэх, програм хангамж бусад материалаар хангах					
5	Малын эрүүл мэндийн нэгдсэн төв (архун цэвэр, эрүүл ахуйн болон байгаль орчны шинжилгээний лаборатори бүхий)-ийн техник эдийн засгийн үндэслэл болон барилгын зураг төсвийг боловсруулах;	2016 он	Ханбогд сумын ЗДТГ	NCCS компани. Улсын мал эмнэлэг, архун цэврийн төв лаборатори	35.0
6	Малын эрүүл мэндийн нэгдсэн төвийн барилга байгууламжийг барьж ашиглалтанд оруулах;	2016-2017 он	Өмнөговь аймгийн ХХААГ	Ханбогд сумын ЗДТГ. Барилгын компани	1.350.0
7	Малын эрүүл мэндийн төвийн лабораторит ажиллах архун цэвэр, эрүүл ахуйн болон байгаль орчны чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх	2017-2019 он	Өмнөговь аймгийн ХХААГ	Ханбогд сумын ЗДТГ. ХААИС	100.0
Мал маллагааны уламжлалт арга-барилыг сэргээх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, мэргэжилтнүүдийг чадваржуулах					
8	Сумын хүн эмнэлгийн салбартай хамтран “Эрүүл малчин” бичил төсөл боловсруулж хэрэгжүүлэх	2016 он	Ханбогд сумын Сум дундын эмнэлэг	Ханбогд сумын ЗДТГ Аймгийн ЭМГ	100.0
9	Салбарын мэргэжилтнүүдэд орчин үеийн программ хангамжуудыг ашиглахад сургах, мал аж ахуйн үйлдвэрлэлийн менежментийн болон технологийн ур чадварыг эзэмшүүлэх;	2017-2018 он	Өмнөговь аймгийн ХХААГ	Ханбогд сумын ЗДТГ. ХААИС Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв	150.0
10	Ахмад малчидтай хамтран малчдын залуу халааг бэлтгэх, бүлэг, хоршоолын ирээдүйн чадварлаг удирдагч, менежерүүдийг бий болгох “Залуу малчин” төсөл хэрэгжүүлэх;	2019-2022 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ. Хоршооллын сургалт мэдээллийн төв	250.0

Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ #1

	Бэлчээр ашиглалт, малыг уламжлалт болон дэвшилтэт технологийн дагуу маллах, малын эрүүл мэнд, ашиг шинийг сайжруулах, байгалийн эрсдэлээс хамгаалах мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх сургалтыг шат дараатай зохион байгуулах;	2023-2025 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв	275.0
Малын эрүүл мэнд, үйлдэрлэг байдлыг сайжруулах, ашиг шинийг нэмэгдүүлэх					
12	Мал аж ахуйн салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, программ хангамжтай болгох замаар сумын мал эмнэлэг, үржлийн тасаг, үйлчилгээний нэгжүүдийг бэхжүүлэх	2017-2020 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ.	140.0
13	Сумын бог малын бүх хээлтүүлэгчийг мэргэжлийн байгууллагын мэдэлд /хяналт/ авах, сайн чанарын өсвөр хээлтүүлэгч бойжуулах “Цөм сүрэг” төсөл хэрэгжүүлэх	2018-2022 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ. Малын удмын сангийн үндэсний төв	450.0
14	Сумын байгаль, цаг агаарын нөхцөлд тохирсон ашиг шим сайтай мал үржүүлэх, “Эрчимжсэн мал аж ахуй” төсөл хэрэгжүүлэх;	2020-2022 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв	300.0
Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөгжүүлэх					
15	Торомны ноосыг самнаж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хонь, тэмээг цахилгаан хайчаар хяргах технологи нэвтрүүлэх;	2018-2019 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ.	300.0
16	Ингэний сүүг боловсруулан эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг дэмжих	2019-2020 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ.	300.0
17	Техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан малын гаралтай түүхий эдийг боловсруулах бусад үйлдвэрлэлийг дэмжих	2020-2021 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ.	400.0
18	Мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах дэвшилт технологий бүхий үйлдвэр бий болгох;	2021-2022 он	Өмнөговь аймгийн ХХААГ	Ханбогд сумын ЗДТГ.	500.0
19	Бүсийн сумдын тэмээ, хонины ноосыг боловсруулах үйлдвэр байгуулж зарим төрлийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих	2022-2024 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ.	400.0
Нийт дүн					5900.00